

2024 01 02. 04



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 17/60

Номгон

Баяр наадам, шашин соёл, ёслол  
хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах  
аймгийн хорооны бүрэлдэхүүнийг  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Тулгар төрийн 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, Ардын хувьсгалын 103, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 113, Баянхонгор аймаг байгуулагдсаны 83 жилийн ойн үндэсний их баяр наадам, Монголын бурхан шашны 3 зулын нэг Эрдэнэбандида хутагт Ханчэн чойгял Хамба номун хан ламын гэгээн Лувсанданзанжанцаны мэлмий гийсний 385 жил, Ламын гэгээний 8 дугаар дүр Данзанжамбалчойжинэн гэгээнтэнд даншүг өргөх шашин соёл, ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах аймгийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2.Хорооны дарга: Аймгийн Засаг даргын Орлогч

-Нарийн бичгийн дарга: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

-Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

-Цэргийн штабын дарга

-Нийтлэг үйлчилгээний албаны дарга

-Цагдаагийн газрын дарга

0121384

- Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Биеийн тамир, спортын газрын дарга
- Соёл, урлагийн газрын дарга
- Хөгжимт драмын театрын дарга
- Хүүхдийн Тэмүжин театрын дарга
- Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч
- Гон гандан дэдлин хийдийн тэргүүн хамба
- Аймгийн морин спорт уяачдын холбооны тэргүүн

2. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх салбар хороо, дэд ажлын хэсийн бүрэлдэхүүнийг байгуулж, ерөнхий удирдлага зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай хөрөнгө санхүүг хандив тусламжаар бүрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д, бэлтгэл ажлыг сайтар хангаж, баяр наамдыг өндөр түвшинд зохион байгуулахыг хорооны дарга бөгөөд аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ